

ТАНИЛЦУУЛГА

2022 ОНЫ 01-04 ДҮГЭЭР УЛИРАЛД САЙХАН-ОВОО СУМЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТУХАЙ

2022.12.27

2022 оны 01-04 дүгээр улиралд Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газарт болон мэргэжилтнүүдэд хандаж “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол улсын хууль, Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 67-р тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон иргэдээс биеэр болон бичгээр нийт-60, байгууллагын дотоод буюу албан хаагч нараас нийт-13 өргөдөл, гомдол, санал хүсэлт, ирүүлснээс 58 өргөдөл, 13 хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 2 өргөдөл, гомдол, санал хүсэлт нь шийдвэрлэх боломжгүй учир хүсэлт гаргагч иргэнд мэдэгдэж 100%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж одоогоор хугацаа хэтрүүлэн шийдсэн өргөдөл гомдол санал хүсэлт гараагүй байна.

Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах нээлттэй утас:**75054499**,

saikhanovoo@dundgovi.gov.mn цахим хаягийг тогтмол ажиллуулж байна.

- Сайхан-Овоо сумын Засаг дарга даргад хандаж өөрийн зардлаар хашаа, хайлс хийж 1 га орчим газрыг эзэмшиж ногоо болон мод тарих-1, Сумын айлуудын хог тээвэрлэх, хогийн цэгт буулгах, дахивар бүтээгдэхүүн худалдан авах, борлуулах-1, Сумын халуун ус, үсчний газрыг ажиллуулах-1, Суманд тусламжийн гэр ирвэл гэртэй болох хүсэлт-1, Мөн Петровис ресурс ХХК-с 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/91 тоот хууль бус захирамжыг хүчингүй болгуулах тухай1, Найз багийн багийн төвд байдаг “Улаан булан” гэх барилгыг ашиглан цагаан идээ хийж борлуулах-1, Дөл хүнсний дэлгүүр нь тамхи худалдан борлуулах зөвшөөрөл авах-1 өргөдөл ирсэнийг цаг тухай бүрт нь хуулийн дагуу шийдвэрлэсэн.
- ГХБХБ-ын сум хариуцсан газрын даамалд хандаж өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмших өргөдөл нийт-49 ирсэнээс 4 багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн бөгөөд 3-р багийн 1 өргөдөл нь хуулийн дагуу газар эзэмшиж болохгүй учир буцаагдаж бусад өргөдөлүүд нь шийдвэрлэгдсэн.
- Нийгмийн бодлогын мэргэжилтэнд хандаж иргэдээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд асран хамгаалагч тогтоолгохоор-2, өргөдөл ирсэнийг цаг тухай бүрт нь шийдвэрлэсэн.

- Нэг өргөдөл гомдлын шийдвэрлэх хугацаа нь 13.2 хоног.
- Малын А данс авахаар-9 хүсэлт, Зэрэг олгосон тушаалын хуулбар авахаар-1 хүсэлт ирсэнийг цаг тухай бүрт нь бүртгэж шийдвэрлэсэн.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:

С.БОЛОРЖАРГАЛ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН:

О.ДАШЗЭВГЭ

2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ,
ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ (ӨССӨН ДҮНГЭЭР)

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Судлах хугацааг сунгасан	Шийдвэрлэлтийн %/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй		
1	Засаг даргын Тамгын газар	60	59				1	99,0%
Дүн		60	59				1	99,0%

ЖИЧ: Шийдвэрлэж хариу өгсөн нийт 59 өргөдлөөс 3-р багийн иргэдийн нийтийн хурлаар оруулсан газар эзэмших өргөдлөөс хуулийн дагуу 2 өргөдөл буцаагдсан болно.